

## **Нягтлан бодох бүртгэлийн (НББ-ийн) мэргэжлийн өнөө ба ирээдүй**

Л. Наранчимэг<sup>1</sup>

Хөгжлийн эрин зуунуудыг худалдааны, үйлдвэрлэлийн, мэдээлэл технологийн эрин гэж ангилдаг. Нийгэм, эдийн засаг, технологи, шинжлэх ухаанд гарч байгаа өөрчлөлтүүд нь НББ-ийн мэргэжилтэн бэлтгэх хэрэгцээ шаардлага, агуулга, ур чадварт шууд нөлөөлсөөр ирсэн, одоо ч нөлөөлсөөр байна. Орчин үед шинжлэх ухаан, технологийн дэвшил, цахим тооцооллын системийн хөгжил зэрэг олон хүчин зүйлүүдтэй холбоотойгоор шинэ мэргэжлүүд үүсэх хурд багасаж, олон арван мэргэжлүүдийн эрэлт хэрэгцээ өөрчлөгдөн, зарим нь жагсаалтаас гарч байгааг Английн Оксфордын их сургуулийн судлаачид судлан тодорхойлсон байсан.

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилд тооцооллын автоматчилагдсан ухаалаг системүүд нэвтэрч, эдийн засгийн тодорхойгүй, тогтворгүй байдал нэмэгдэж компьютерийн программ хангамж сайжрахын хэрээр НББ-ийн мэргэжлийн даяарчлал, стандартчилал, бизнес дэх “Үүлэн тооцоолол”, мэргэжлийн шинэ үеийнхний ялгаатай хүсэл эрмэлзлэл болон шинэ хүлээлтүүд бий болсоор байна. НББ-ийн мэргэжил нь сонирхогч талуудын шаардлагатай ажлууд дээр хүчээ сорих, манлайлах боломжийг олгож,

санхүүгийн тогтвортой байдал, өрсөлдөх чадварыг сайжруулах, түүнийг дэмжих үйл хэрэгт тэргүүн эгнээнд явж байна. Дэлхийн 150 орны 36-аас доош насны 19,000 мэргэжилтнээс судалгаа авахад санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр олон жил ажиллах ирээдүй бий, ажлын байраа дэлхийн хэмжээнд сэтгэж байна, дижитал технологийг ашиглах нь мэргэжилд улам их давуу талыг бий болгоно гэж хариулсан судалгаа ч байдаг. Манай улсын хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар дээд мэргэжилтэй нягтлан бодогчийн эрэлт хэрэгцээ жилээс жилд нэмэгдсээр байна. 2018 онд хөдөлмөрийн зах зээлд 74.6 мянган ажиллах хүчний эрэлт үүсч, 25.0 хувь нь барилгын салбарт, 20.4 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 10.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 7.2 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 6.4 хувь нь мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, 6.0 хувь нь хөдөө аж ахуйн салбаруудад тус тус бий болж байгаа нь нийт эрэлтийн 75.8 хувийг эзэлж байна. Ажиллах хүчний нийт эрэлтийн 71.5 хувь нь байнгын, 28.5 хувь нь түр зуурын эрэлт, 65.3 хувь нь шинэ, 34.7 хувь нь сул ажлын байрны эрэлт эзэлж, түр зуурын эрэлтэд барилгын салбарын

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн доктор, профессор  
E-mail: naranchimeg\_l@num.edu.mn

ажиллах хүчний эрэлт голлон нөлөөлж, хөдөлмөрийн зах зээлийн хамгийн их эрэлттэй ажил мэргэжилд Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил эхний 5-д багтсаар байгааг дараах судалгаа харуулж байна<sup>2</sup>.

Хүснэгт 1. Эрэлттэй ажил, мэргэжил

2017 онд	2018 онд
- Технологич	- Инженер (иргэний барилгын)
- Их эмч	- Инженер (хийн хоолойн)
- Барилгын инженер	- Нягтлан бодогч (ерөнхий)
- Нягтлан бодогч	- Бусад энгийн мэргэжлүүд
- Багш	
- Бусад энгийн ажил мэргэжлүүд	

Дээд, тусгай боловсролын гэхээсээ илүүтэй мэргэшсэн ажил мэргэжлүүдийн эрэлт зонхилж байгаа боловч тэдгээрийн дараагаар Нягтлан бодогч (Ерөнхий), Барилгын инженер зэрэг мэргэжлүүд орж ирж байна.

Тухайлбал, 2018 оны байдлаар ерөнхий нягтлан бодогч, нийт ажиллах хүчний эрэлтийн 1.3 хувийг эзэлж, энэ мэргэжлийн эрэлтийн 80-100 хувь нь хүйс харгалзахгүйгээр ажилтан авах хэрэгцээ


байгааг судалгааны дүн харуулж байна.

Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа эдийн засгийн нөөцүүдийг хэрхэн зөв хуваарилж, үр дүнтэй ашиглах нь шийдвэр гаргагчдад хамгийн чухал зүйл. Шийдвэр гаргалтанд цаг үеэ олсон, үнэн зөв, бодитой мэдээлэл зайлшгүй шаардлагатай бөгөөд энд бүртгэлээр бий болж буй мэдээллийн үүрэг асар их юм. Дээд боловсролоор олгох мэргэжлүүдийн интеграц хүчтэй явагдаж, салбарын техник технологитой хосолсон мэргэжлийн (уул уурхайн инженер, эдийн засагч, үйлдвэрлэлийн технологи, нягтлан бодогч гэх мэт) эрэлт нэмэгдэх хандлага байна.

Дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалт (ДНБЧУ) 4 жилд 1 удаа зохион байгуулагддаг бөгөөд 2018 оны 11 сард Австрали улсын Сидней хотод ээлжит чуулган зохион байгуулагдсан юм. Энэ чуулга уулзалтаар ирэх арван жилд НББ-ийн мэргэжил маань хэрхэн хувьсан өөрчлөгдөх вэ? гэдгийг судлаачид илүү хэлэлцэж НББ-ийн мэргэжлийн чиг хандлагыг дараах 5 зүйлээр

Зураг 1. Ажиллах хүчний эрэлт

Ажиллах хүчний эрэлт, нийт эрэлтэд эзлэх хувиар



<sup>2</sup> Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн Барометрийн судалгаа 2017, 54-56 хуудас

тодорхойлжээ<sup>3</sup>.

- Өмнөхөөс илүү үнэ цэнийг бүтээнэ (Adding more value than ever),
- Залуу үеийнхэн хүчтэй түрэн орж ирнэ (Younger generation will rise /and rise/),
- Дэлхий дахины эрхэм зорилго (Planetary mission),
- Энэ сэтгэл хөдөлгөм байх болно (It is going to be emotional),
- Итгэлийг дахин сэргээх нь (Rebuilding trust).

Өмнөхөөс илүү үнэ цэнийг бүтээнэ

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил байнгын давтагдах, ижил төрлийн гүйлгээг бүртгэх ажил үүргээсээ чөлөөлөгдөж, ажил олгогч болон харилцагчиддаа илүү их үнэ цэнэ бүтээж өгөхөд анхаарах боломжтой болжээ. Энэ агуулга Дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалтын турш, ялангуяа хиймэл оюун ухаан, роботик, эд юмсын интернет (internet of things), автомат төлбөр тооцоо болон блокчейний тухай илтгэлүүд дээр олонтоо давтагдаж байлаа.

"Компанийхаа санхүүгийн эрүүл мэндэд анхаарах нь нягтлан бодогчдын хамгийн том хариуцлага, дэлхий даяар маш олон шинэ инновациуд гарчирж байна", "Нягтлан бодогчдод олон арга хэрэгслүүд бий болж байгаад би маш их баярлаж байна" гэж Сингапурт төвтэй хиймэл оюун ухаанд суурилсан шийдлийн компани болох Addo AI-ийн хамтран үүсгэн байгуулагч, CEO Айша Ханна хэлжээ. Тэрээр чуулганы турш давамгайлж буй энэхүү төлвийг нэгтгэн дүгнэж: "Технологийн инноваци болон хүний мэргэн ухаан хоёроор дамжуулан бид өдөр тутмын үүрэг даалгавруудаа орхин өөрсдийн оюун санаагаа өргөжүүлэх боломжтой болж байна. Ингэснээр

бид дэлхий дээрхи хамгийн үнэтэй нөхөн сэргээгдэхгүй таваар болох ЦАГ ХУГАЦАА-г чөлөөлж өгч байгаа юм. Өндөр үнэ цэнэтэй стратегийн зөвлөгөө өгөхөд илүү их цагийг зарцуулъя. Тогтвортой хөгжил цэцэглэлтийг урагшлуулах илүү их цаг. Олон нийтийн өмнө хүлээсэн эрхэм зорилгоо биелүүлэх илүү их цаг. Бид үүнийг хийж чадах уу? Би мэдэж байна: Бид чадна" хэмээжээ.

Залуу үеийнхэн хүчтэй түрэн орж ирнэ

Дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалтаар заавал хөндөгдөх ёстой нэг сэдэв бол шинэ, дараагийн үеийн нягтлан бодогчид хүсэл зорилготой, мэргэжлээ дахин төсөөлөхөд бэлэн байгаа эсэх асуудал байлаа. Амжилттай яваа шилдэг залуу мэргэжилтнүүд өөрсдийн нягтлан бодох бүртгэлийн ур чадвараа бизнесийн болон нийгмийн асуудлуудыг шийдэхэд хэрхэн ашиглаж байгаа талаараа хэд хэдэн илтгэл хэлэлцүүлжээ.

"Шинэ үеийн нягтлангууд бидний эгнээнд нэгдсэнээр бид ирээдүйд нягтлан бодох бүртгэл ямар байж болох талаар өөр өөр алсын хараатай болоод байна" хэмээн Австралийн PWC компанийн захирал Шелли Кайбл хэлжээ. Тэрээр "Би олон олон шинэ, залуу нягтлан бодогчдыг манлайллын үүрэг хүлээж аваасай гэж хүсдэг, мөн бид өөрчлөлт хийж чадна хэмээн итгэдэг, яагаад гэвэл бид үнэхээр чадах учраас" гэжээ. "Биднийг бидний төсөөлөл л хязгаарлаж чадна, өөр юу ч биднийг хойш нь татаж чадахгүй юм" гээд, Кайбл залуу нягтлангууд салбаруудад нэгэнт байр сууриа олсон манлайлагчидтай хамтран зүтгэх маш их хүсэлтэй байдгийг онцолжээ. Тэр хэлэхдээ: "Бид та бүхэнтэй хамт алхмаар байна. Бид та бүхний

<sup>3</sup> GAPE, Global Academy Professional Education

туршлагаас суралцмаар байна. Мөн бид үүнийг өөрсдийн эрч хүч болон ирээдүйн талаарх алсын хараатайгаа нэгтгэмээр байна" гэжээ.

#### Дэлхий дахины эрхэм зорилго

Нягтлан бодогчид нь тоон болон тоон бус өгөгдөлтэй ажиллах, өгөгдлийг боловсруулах, нотлох мэргэжлийн чадвартай хүмүүс. Энэхүү чадвараа ашиглан эх дэлхийнхээ тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад тэд онцгой байр суурь эзэлнэ. Энэ бол Английн ханхүү Чарльз болон НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга асан Бан Ки Мун нарын ДНБЧУ-нд ирүүлсэн санал, санаачлага байлаа.

"Хүн болгон хариуцлагаа ухамсарлан, хийж байгаа ажил нь ил тод болсон цагт энх тайван, шудрага байдал тогтоно" хэмээн Бан Ки Мун хэлжээ. "Хамтын зүтгэлээ өргөжүүлж, НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээнүүдэд дэмжлэг үзүүлж ажилласнаар эх дэлхийдээ илүү хариуцлагатай, ухамсартай хандацгаая. Та бүхэн бол "accountants". Энэ үг нь Accountability буюу хариуцлагатай байх, хариуцлагаа ухамсарлах гэх үгнээс гаралтай. Тиймээс эх дэлхийгээ хайрлан хамгаалахын тулд хамтран ажиллацгаая". Бидэнд хүргүүлсэн видео мэндчилгээндээ, Ханхүү Чарльз "Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг шийдэмгий алхам хийхэд нягтлан бодогчид туслах ёстой" хэмээжээ. Түүний хэлснээр, санхүүгийн салбарын манлайлагчид тогтвортой, үр ашигтай бизнесийн загваруудыг бий болгох чадвартай, мөн үүрэгтэй гэжээ<sup>4</sup>.

#### Энэ сэтгэл хөдөлгөм байх болно

АССА-ийн гүйцэтгэх захирал Хэлэн Бренд "Хурдацтай өөрчлөгдөж буй дижитал цаг үед амжилттай байхын тулд мэргэшсэн нягтлан бодогч нь мэргэжлийн мэдлэг, үр чадвараас гадна бусад үр чадваруудыг эзэмшсэн байх хэрэгтэй. Үүнд сэтгэл хөдлөлөө удирдах чадвар ч багтаж байна" гээд ДНБЧУ-нд оролцсон төлөөлөгчдийг сэтгэл хөдлөлөө удирдах чадвараа өөрсдийн санаачлагаар хөгжүүлэхийг уриалсан юм. Үүнд, өсөлтийн сэтгэлгээ, өөрийгөө таньж мэдэх, бусдыг ойлгох, нөлөөлөх гэх зэрэг чадамжууд багтана.

Өдөр тутмын хэвшмэл ажлуудыг ирээдүйд технологийн тусламжтай хийж гүйцэтгэх ч, зөвхөн хүн л нэг нэгнийхээ сэтгэл хөдлөлийг тодорхойлж, оновчтой хариу үйлдэл үзүүлж чадах юм. "Олон хүмүүс сэтгэл хөдлөлийг мэдрэх төрөлхийн чадвартай байдаг нь тэдэнд хүмүүстэй үр дүнтэй харилцах, ойлголцоход нь тусладаг. Аливаа үйл ажиллагаанд энэхүү үнэ цэнийг тусгах нь цахим эринд өндөр ач холбогдолтой. Энэ үнэ цэнийг олж авсанаар амжилтанд илүү ойртоно".

#### Итгэлийг дахин сэргээх нь

Дэлхий даяар бизнесүүдэд итгэх олон нийтийн итгэл буурч байгаа нь мэдээллийн хэрэгсэл болон олон тооны санал асуулгын хариултаар илэрч байна.

ДНБЧУ-нд оролцсон төлөөлөгчдөд энэ талаар Майкл Вүүдфүрд (Olympus-ийн CEO асан, 2011 онд 100 тэрбум иений бүртгэлийн луйвар илрүүлсэн) болон Венди Аддисон (LeisureNet санхүүгийн менежер асан) нарын илтгэлээс сонссон юм.

<sup>4</sup> accountingforsustainability.org

Тэд бизнесийн байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг сэргээхэд мэргэшсэн нягтлан бодогчид маш чухал оролцоотой талаар яг цагаа олж сануулсан юм.

Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны ерөнхийлөгч асан Рэчл Гримс “Ёс зүй биднийг бусад мэргэжлээс ялгадаг” хэмээн хэлжээ. “Итгэл бол бизнесийн эзэмшсэн байх хамгийн чухал үнэт хөрөнгө юм”. Ёс зүйн зөвлөх Клер Пейн хэлэхдээ “Нягтлан бодогчид олон нийтийн итгэлийг олохын тулд хуулийн нийцлийг хангахаас илүүтэйгээр хичээж ажиллах хэрэгтэй” гэжээ. Нийгмийн хүлээлт магадгүй стандартын шинэчлэлээс илүү хурдацтайгаар өөрчлөгдөнө. Нягтлан бодогчдоос бизнес эрхлэгчдэд өгч буй зөвлөгөөгөө хэр ёс суртахуунд нийцэж буй талаар бодож, байнга анхаарч байх нь улам чухал болж байна гэдгийг тэрээр сануулсан юм.

### Дүгнэлт

Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулалт, тооцооллын ажиллагаа нь улам бүр компьютержиж, мэргэжилтний оролцоо багасаж байгаа хэдий ч Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар дээд боловсрол шаардагдах эрэлттэй мэргэжлийн ТОП-5-д нягтлан бодогч орсоор байна.

Даяарчлагдсан, автоматчлагдсан өнөө

үед бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайтар хянан сайжруулж, тэдэнд чухам ямар мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх вэ? гэдгийг эргэн харж, шүүн хэлэлцэх, НББ-ийн мэргэжилтэн бэлтгэх үндэсний стандартыг шинэчлэн боловсруулах, төгсгөж буй оюутнууддаа “Техникийн ур чадвар болон ёс зүйтэй байх”, “Оюунлаг байх”, “Бүтээлч байх”, “Дижитал технологийг ашиглах чадвартай байх”, “Сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах, барих, ашиглах чадвартай байх”, “Ирээдүйг урьдчилан харах чадвартай байх”, “Туршлага хуримтлуулах (Мэргэжлийн, бизнесийн, харилцааны)” гэх мэт ур чадварыг эзэмшүүлэх нь чухал зорилт болж байна.

Мэргэжлийнхээ ур чадвараа хөгжүүлэхэд тасралтгүй анхаарч, бизнесийн зөвлөх үйлчилгээнд суралцаж, мэргэжлийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамтарч ажиллах, харилцан суралцах, ёс зүйтэй байх эрхэм чанарт илүүтэй суралцах нь бидний амжилтын хөдөлгүүр болох төдийгүй дэлхийн хөгжлийн чиг хандлагад бэлэн байх боломжийг олгоно. Өмнө дурьдсан “Ажлын байраа дэлхийн хэмжээнд сэтгэж, дижитал технологийг ашиглах нь мэргэжилд улам их давуу талыг бий болгоно” гэдэг судалгааны хариулттай санал нэг байгаагаа илэрхийлж байна.

### Ашигласан материал

1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн Барометрийн судалгаа 2017
2. Дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалтын илтгэлүүд
3. <http://www.accountingforsustainability.org>
4. <https://gape.education/default.aspx?page=1>

